



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Улаанбаатар хот

2013 оны 6 дугаар сар

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	2
ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар	Аудитын гэрчилгээ	4
Газрын захирал С.Энхзаяа	Нэг. Ерөнхий зүйл	
	Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....	6
	Аудитын зорилт, хамарсан хүрээ	6
	Аудитын арга зүй.....	6
Хэлтсийн захирал-менежер С.Оюунгэрэл Г.Нямдорж	ЗГ-ын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....	6
	Хоёр. Аудитын санал дүгнэлтийн талаар	
	Аудитын санал дүгнэлтийн үндэслэл.....	8
Ахлах аудитор Ч.Болд Г.Юра Ц.Гэрэл Л.Одгэрэл Ц.Сугармаа	Гурав. Санхүүгийн дотоод хяналтын талаар	9
	Дөрөв. Аудитаар илрүүлсэн зүйлс, тэдгээрийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө	
	4.1 Мөнгөн хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна	10
	4.2 Тайлант онд бусад зардлын тооцооны бодит бус авлага, өглөг үүсгэсэн байна.....	10
	4.3 ЗГСНТ-аарх бараа материалын үлдэгдэл 43 хувиар өссөн байна	11
	4.4 Засгийн газрын урт хугацаат өр төлбөр 1.7 дахин нэмэгджээ	12
	4.5 Гадаад зээлээс дотоодод дамжуулан зээлдүүлсэн хөрөнгийн эргэн төлөлт хангалтгүй байна	13
	4.6 Төрийн өмчийн хорооны зарим шийдвэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нийцэхгүй байна	16
	4.7 Төрийн сан дахь НДС-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд хүү төлөгдөхгүй байна.....	16
	4.8 Хүний хөгжил сангийн санхүүгийн тайлан 1,057.8 тэрбум төгрөгийн алдагдалтай тайлагнагджээ	17
Аудитор И.Туяа Ж.Ядмаа Ш.Отгонбаяр Д.Уртнасан Ш.Ичинхорлоо Б.Даваабаатар Р.Цолмон П.Чанцалдулам	Тав. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар	18
Туслах аудитор Л.Мөнхцацрал	Зургаа. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар	20
2013 оны 6 дугаар сар	Долоо. ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар	21
Уг тайланг ҮАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү:	Найм. Тайлант оны аудитын зөвлөмж	27
www.mnao.mn	Ес. Засгийн газрын 2012 оны аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан	29
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.	9.1 Засгийн газрын аудит хийгдсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	
	9.2 Засгийн газрын аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	
	9.3 Засгийн газрын аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
	9.4 Засгийн газрын аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3, Улаанбаатар-15160 Монгол Улс	Арав. Хавсралтууд	33
	А. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын мэдээ	
	Б. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын мэдээ	
	В. Аудитын дүнгийн нэгдсэн судалгаа	

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард Улс
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДБҮААЭГ	Дипломат байгууллагын үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар
ДСЦТС	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГ	Засгийн газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МЦХ	Монголын цахилгаан холбоо
МШХХТГ	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХҮХ	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОССК	Орон сууцны санхүүжилтийн корпораци
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
СБД	Сүхбаатар дүүрэг
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга

ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
УЕПГ	Улсын Ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХОТШ	Хөрөнгө оруулалт технологийн шинэчлэлт
ХТҮ	Хар төмөрлөгийн үйлдвэр
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХХС	Хүний хөгжил сан
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210546 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-68

2013.05.07 № 821

танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Засгийн газар санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуульд заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), тэдгээрт нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулалгүй зөрүүтэй тайлагнасан, бонд гаргасантай холбоотой зардлыг баримтын бүрдэлгүйгээр бүртгэлд

075365

тусгасан, дамжуулан зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, бүрэн тусгаж баталгаажуулаагүй, хүүгийн зардлыг давхардуулан тайлагнасан, нийт авлага, өр төлбөрийн дийлэнх хувийг эзэлж байгаа Төв төрийн сангийн гүйлгээг Сангийн сайдын төсвийн багцын тайланд тусгаагүй нь бидний өгөх санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэж байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан зөрчилтэй асуудлын санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, үр дүн, (цэвэр хөрөнгө) өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Үндэсний аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасан бүрэн эрхийн дагуу Засгийн газрын 2012 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Үндэсний аудитын газар Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагчдын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, Теам Мате, IDEA програм хангамж ашиглан хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Аудитыг гүйцэтгэх хугацаа, боловсон хүчний нөөц хязгаарлагдмал байснаас шалтгаалан Засгийн газрын 2012 оны санхүүгийн зөвхөн үндсэн тайлангуудад аудит хийж санал дүгнэлт гаргасан болно.

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54.1, 54.2 дахь заалтын дагуу Засгийн газрын 2012 оны санхүүгийн тайланг нэгтгэж, бэлтгэсэн боловч хуульд заасан хугацаанд ирүүлсэн санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл, үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланг өмнөх оны аудитаар баталгаажуулсан тайлангаас

зөрүүтэй тайлагнасан нь АОУС 510-ыг зөрчсөн тул аудитын явцад залруулан гаргуулсан болно. Тайланд дараах тайлангуудыг нэгтгэсэн байна. Үүнд:

- Улс, орон нутгийн ТЕЗ-дын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Төрийн өмчит 87, орон нутгийн өмчит 165 аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан
- Төв төрийн сангийн 2012 оны санхүүгийн тайлан
- Хүний хөгжил сангийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан
- Нийгмийн даатгалын сангийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим
Засгийн газрын санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	Толилуулгын суурь
Засгийн газрын мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
Засгийн газрын өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудаас Өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ын дагуу “Plastic 1.0” програмаар бэлтгэн гаргажээ.

Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангийн маягт нь УСНББОУС(1)-д заасан шаардлагыг хангахгүй байгаагаас уг тайланг стандартаар батлагдсан маягтын дагуу тайлагнасан байна.

Сангийн яам Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-ын дагуу бэлтгэн гаргахыг зорьж, стандартад заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузл суурийг хэрэглэсэн байна.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- Тайлант онд шинээр байгуулагдсан Эрдэнэсант АЗЗА, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор, Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв, Багануур АЗЗА, Монгол ус, Хот байгуулалт, барилгын зураг төслийн институт, Эрчим хүчний газар, Эрчим корпораци, Дөргөний усан цахилгаан станц зэрэг 10 аж ахуйн нэгжийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдлийг оруулан нэгтгэсэн байна.

Сангийн яам УСНББОУС-д заасан шилжилтийн нөхцөлийг Сангийн сайдын 2009 оны 263 дугаар тушаалаар шинэчлэн баталж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг стандартад нийцүүлэх цаг хугацааг баримтлан ажиллаж байгаатай холбоотойгоор:

- Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн гүйлгээг цэвэрлэж, нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын хооронд давхардсан зарим ажил гүйлгээг байгууллагуудаас гаргуулан аваагүйгээс давхардлыг бүрэн арилгаагүй байна.
- Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд бүх төсвийн ерөнхийлөн захирагчид, төрийн сан, төсөл, сангууд, 100 хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нэгтгэлийн дүнг тус тусад нь баганаар харуулжээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

Хоёр. Аудитын санал дүгнэлтийн талаар

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн нь Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгөх үндэслэл боллоо. Үүнд:

- Татан буугдсан Анод банкинд байршиж буй тусламжийн орлогын хадгаламжийн дансны 9.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1.4 тэрбум төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Чингис бонд гаргах, худалдан борлуулахтай холбогдон гарсан 5.4 сая ам.доллартай тэнцэх зардлыг баримтын бүрдэлгүйгээр хүүгийн зардалд бүртгэсэн,
- Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зарим авлагын эргэн төлөлт 7-20 жилээр хугацаа хэтэрсэн, 660.9 тэрбум төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- АХБ, Дэлхийн банкны эх үүсвэрээр 1991-1993 онд нэр бүхий 29 аж ахуйн нэгжид дамжуулан зээлдүүлсэн 64.6 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг харилцагч бүрээр гэрээ хийж бүртгэлд тусгаагүй,
- Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газарт 2012 оноос эхлэн хэрэгжиж буй “Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн хүрээнд 45,649.6 мянган ам.долларыг дамжуулан зээлдүүлэх төсөл хүчин төгөлдөр болсныг үндэслэн зээлийн гэрээ байгуулаагүйгээр тайлант онд 9.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, дамжуулан зээлийн авлагаар бүртгэсэн,
- 2011 онд Мал хамгаалах сангаар дамжуулан ноосны урамшуулалд олгосон бондын санхүүжилтийн 9.8 тэрбум төгрөгийг Төрийн сангийн авлагын бүртгэлд тусгасан,
- Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хуримтлалын сангийн хөрөнгөөр ҮХААЯ-ны захиалгаар хийгдсэн Төв аймгийн Угтаалцайдам сум дахь 36,000 тн багтаамжтай үр тарианы элеватор сэргээн засварлах ажлын санхүүжилтийн 3,957.2 сая төгрөгийг Сангийн яамнаас гэрээт компанид

шууд санхүүжүүлснээс шалтгаалан ҮХААЯ-ны 2012 оны жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайланд тусгаагүй,

- Засгийн газрын 2012 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд хүүгийн зардлыг 165.1 тэрбум төгрөгөөр давхардуулж тайлагнасан,
- 2011-2012 онд ашиглалтад орсон нийт 13.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилга байгууламжийг дуусаагүй барилга данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгээгүй.

Дээр дурдсан зөрчилтэй асуудлын санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Гурав. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газар /хуучин нэрээр/ 2012 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Төрийн сангийн түр саатлын дансны 2011 оны үйл ажиллагаанд;
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2011 оны тайланд;
- Засгийн газрын тусгай сангуудын төсөв, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд;
- Боловсрол, соёл шинжлэх ухааны яам /хуучин нэрээр/-ны болон Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаанд;
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагаанд;
- Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд;
- Монгол Улсын төсвийн тогтворжуулалтын сангийн 2011 он, 2012 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд;
- Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн байдалд;
- Төв аймгийн 2011, 2012 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүү, төрийн сангийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тус тус дотоод аудит хийж, тайлан дүгнэлт гаргаж хэлэлцүүлэн, зөвлөмж өгч ажиллажээ.

Үндэсний аудитын газраас Засгийн газрын 2011 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2011 оны гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар тайлант онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж, Сангийн сайдын 2012 оны 163 дугаар тушаалаар батлуулан яамны холбогдох газруудад хүргүүлж, биелэлтийг нь авч нэгтгэн тайлагнажээ.

Засгийн газрын 2011 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 10 зөвлөмж өгсөн бөгөөд 3-ыг нь бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн тайланг нэгтгэн гаргах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хяналтыг сайжруулах,
- Төв төрийн сангийн санхүүгийн тайланд аудит хийлгэсний дараа ЗГСНТ-д нэгтгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах,
- Сангийн яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, арилжааны банкуудтай хийсэн гэрээнд иргэдийн аваагүй үлдэгдэл хөрөнгийг иргэдийн

нэрээр банк, ХХҮГ хоорондоо тулган баталгаажуулах, тайлагнах асуудлыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Дөрөв. Аудитаар илрүүлсэн зүйлс, тэдгээрийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө

4.1 Мөнгөн хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна

Сангийн яам 2007 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Анод банкинд хугацаагүй хадгаламжийн данс нээж Япон Улсын тусламжийн 1.5 тэрбум төгрөгийг байршуулж, 2007-2009 онд нийт 9 удаагийн гүйлгээгээр 8.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, зарлага гараагүй бөгөөд хуримтлуулж тооцсон хүүгийн хамт 2012 оны эцэст нийт 9.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 1.4 тэрбум төгрөгөөр дутуу тайлагнажээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,574.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2 дахин өссөн бөгөөд үүний 21.7 хувь буюу 776.5 тэрбум төгрөг арилжааны банкинд байршиж байна. Үүний дотор Засгийн газрын зарим тусгай сан, төсвийн орлого, төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламж, барьцаа хөрөнгө, техник хяналтын болон сургалтын зардал, ахмадын сангийн нийт 27.2 тэрбум төгрөгийн үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Монголбанкн дахь Засгийн газрын бондын харилцах дансанд 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр олон улсын зах зээлд арилжсан бондын эх үүсвэрээс 1,494,623.1 мянган ам.долларын орлого орж, 5,376.9 мянган ам.долларын эх үүсвэрийг гэрээний дагуу суутгасан байна.

Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 213 дугаар тогтоол, Сангийн сайдын мөн өдрийн 297 дугаар тушаалаар Засгийн газрын үнэт цаасыг олон улсад сурталчлах, худалдан борлуулахтай холбогдон гарсан дээрх зардлыг нөхөн санхүүжүүлэхээр шийдвэрлэснийг үндэслэн баримтын бүрдэлгүйгээр 7.5 тэрбум төгрөгийг хүүгийн зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Засгийн газрын үнэт цаасыг олон улсад сурталчлах, худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлын зарцуулагдаагүй хөрөнгийн үлдэгдэл 379.3 мянган ам.доллар буюу Монголбанкны албан ханшаар тооцон 0.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх, 7.0 тэрбум төгрөгийн баримтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

4.2 Тайлант онд бусад зардлын тооцооны бодит бус авлага , өглөг үүсгэсэн байна

Сангийн сайдын 2012 оны 295 дугаар тушаалаар бүх төсөвт байгууллагуудын харилцах дансдын үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлснээс шалтгаалан 104.2 тэрбум төгрөгийн авлага, 176.4 тэрбум төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай

хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Засгийн газрын 2012 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд 131.0 тэрбум төгрөгийн хүүгийн зардлыг давхардуулж бүртгэсэн, 34.1 тэрбум төгрөгийг зардлын ангилал зөрүүтэй тусгасан, нийт 165.1 тэрбум төгрөгийн зардлыг алдаатай тайлагнасныг залрууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 119 дүгээр тогтоолыг үндэслэн “Сансрын хиймэл дагуулаар телевизийн 10 сувгийн нэвтрүүлэг орон даяар дамжуулах үйлчилгээний төлбөрийн гэрээ”-г Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Жем Интернэшнл ХХК-тай 10 жилийн хугацаатай, жил бүр 1.2 сая ам доллар төлөх нөхцөлтэй байгуулжээ.

Гэвч дээрх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлсний үндсэн дээр төлбөр гүйцэтгэх талаар гэрээнд тодорхой тусгаагүй, Засгийн газар орон даяар дамжуулах 10 сувгийн нэрийг тогтоож өгөөгүй, гэрээний хэрэгжилтийг үнэлэхгүйгээр санхүүжилтийг олгож, тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Төв төрийн сангийн санхүүгийн тайланд зарим байгууллагатай хийх тооцоог нэр, данс зөрүүтэй тусгасан зөрчил илэрлээ. Тухайлбал, Орон сууц санхүүжилтийн корпорациас авах бондын авлагын 2010 оны үлдэгдэл 80.0 тэрбум төгрөгийг Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд нэр бүхий арилжааны 3 банкнаас авах авлагаар, 2011 онд үүссэн бондын авлагын 72.0 тэрбум төгрөгийг авлагын дансанд ОССК-иас авах авлагаар тус тус бүртгэсэн зөрчил илэрснийг зөв ангилан бүртгэх талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.3 ЗГСНТ-аарх бараа материалын үлдэгдэл 43 хувиар өссөн байна

ЗГСНТ-аарх бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 343.2 тэрбум төгрөгөөр буюу 43.0 хувиар нэмэгдсэнээс дуусаагүй үйлдвэрлэл 127.7 тэрбум төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 59.5 тэрбум төгрөгөөр, нөөцийн бараа 3.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Бараа материал нь эргэлтийн хөрөнгөд 11.5 хувь, нийт хөрөнгөд 6.4 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос эргэлтийн хөрөнгөд эзлэх хувийн жин 3.0 хувиар буурсан байна.

/сая төгрөг/

Үзүүлэлт	2011 он	2012 он	Өсөлтийн дүн	Хувь
Бараа материал	797,668.4	1,140,857.2	343,188.7	43%
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,514,260.0	9,893,795.1	4,379,535.1	79%
Нийт хөрөнгийн дүн	13,055,914.5	17,729,792.1	4,673,877.6	36%
Эргэлтийн хөрөнгөд эзлэх бараа материалын хувийн жин	14.5%	11.5%		-3.0%
Нийт хөрөнгөд эзлэх бараа материалын хувийн жин	6.1%	6.4%		0.3%

Нөөцийн зарим нэр төрлийн барааны ашиглалтын хугацаа дууссан байна. Тухайлбал, Улсын нөөцөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, шатахуун

зарцуулалт ихтэй, сэлбэг хэрэгслийн олдоц ховор, эдийн засгийн үр ашиг багатай автомашинуудыг холбогдох журмын дагуу сэлбэн шинэчлэх шаардлагатай байна.

ЗГСНТ-аар тайлант оны эцэст дуусаагүй үйлдвэрлэлд бүртгэсэн хөрөнгийн дүн 351.2 тэрбум төгрөг буюу 57.3 хувиар өсчээ. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн хөрөнгийн 93.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байгаа нь холбогдох стандарт журмыг зөрчсөн байна.

4.4 Засгийн газрын урт хугацаат өр төлбөр 1.7 дахин нэмэгджээ

Төв Төрийн сангийн тайлангаар Засгийн газрын урт хугацаат өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 3,279.9 тэрбум төгрөг байснаас 2,178.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 5,458.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнд:

- Монголбанкин дахь ОУВС-ийн “Стэнд бай” хөтөлбөрийн үнэт цаасны төлбөрт хуваарийн дагуу 43.2 тэрбум төгрөгтэй тэнцэх валютын төлбөрийг шилжүүлсэн,
- Засгийн газрын шугамаар тайлант онд Олон улсын банк санхүүгийн байгууллага, гадаад улс орноос 271.7 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашиглан, 89.1 тэрбум төгрөгийг эргүүлэн төлж, 46.9 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүг тооцсон,
- Засгийн газар дэд бүтцийг хөгжүүлэх, эдийн засгийн өндөр ач холбогдолтой, нэн тэргүүний хөрөнгө оруулалтад ашиглах зориулалтаар 2012 оны 12 дугаар сард 1.5 тэрбум ам.долларын “Чингис бонд”-ыг олон улсын зах зээлд гаргаж, Монголбанкны ханшаар тооцон 2,088.2 тэрбум төгрөгөөр бүртгэлд тусгасан зэрэг нь голлон нөлөөлжээ.

Гадаад зээлийн үлдэгдлийг салбарын ангиллаар харуулбал:

Ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	СС-ын 2012 оны 82 дугаар тушаалаар залруулсан гүйлгээ		Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл
				нэмэгдсэн	хасагдсан		
Төслийн зээл	1,791.8	234.2	57.8	56.0	21.1	(31.5)	1,971.7
Авто замын зээл	274.0	2.7	10.4	3.1	0.7	0.7	269.4
Санхүүгийн зээл	555.4	8.1	17.5	2.2	0.5	(14.6)	533.2
Хөтөлбөрийн зээл	42.1	26.7	-	-	-	(1.5)	67.3
ОУВС-ийн зээл	6.0	-	3.4	4.8	3.8		3.5
Нийт	2,669.3	271.7	89.1	66.1	26.1	(46.9)	2,845.0

2011 оныг хүртэлх хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдлийг түншлэгч орон, олон улсын санхүүгийн байгууллагын үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байгаагүйгээс Сангийн яамны өрийн удирдлагын бүртгэлийн системд гадаад зээлийн ашиглалтыг зөрүүтэй бүртгэн, гүйцэтгэлийн мэдээ, тайлан тэнцэлд дутуу тайлагнаж ирсэн байна.

Иймд тайлант онд Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийн дүнтэй тулган баталгаажуулсан тооцоог үндэслэн гадаад зээлийн үлдэгдлийн зөрүүтэй бүртгэлийг залруулах зорилгоор Сангийн сайдын 2013 оны 82 дугаар тушаалаар Засгийн газрын гадаад зээлийн 2012 оны жилийн эцсийн үлдэгдлийг 66.1 тэрбум төгрөгөөр өсгөх, 26.1 тэрбум төгрөгөөр бууруулах бичилт хийж залруулснаар нийт 40.0 тэрбум төгрөгөөр үлдэгдлийг нэмэгдүүлэн бүртгэжээ.

Байгууллага	2012 01.01-ний ілдэгдэл				2012 12.31-ний ілдэгдэл		Нийт дүнд эзлэх хувь
	Байгууллагын тоо	Дүн /сая төгрөгөөр/	Нэмэгдсэн	Хасагдсан	Байгууллагын тоо	Дүн /сая төгрөгөөр/	
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	30	143,093.3	66,468.2	42,484.1	32	167,077.4	13.8
Төрийн өмчит аж ахуйн нэгжид олгосон зээл	63	756,224.4	37,915.3	55,999.5	66	738,140.3	60.8
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	163	291,369.6	65,279.5	47,728.0	148	308,921.0	25.4
Нийт дүн	256	1,190,687.3	169,663.0	146,211.6	246	1,214,138.7	100.0

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийг салбарын ангиллаар авч үзвэл Эрчим хүчний салбар 34.3 хувь, Зам тээврийн салбар 17.5 хувь, Жижиг дунд үйлдвэрийн салбар 8.0 хувь, Орон сууц, нийтийн аж ахуйн салбар 13.4 хувь, Харилцаа холбооны салбар 7.1 хувь, хуулийн байгууллагаар хянуулан шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн зээл 14.4 хувь, бусад салбар 5.2 хувийг тус тус эзэлж байна.

2012 онд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөөр үндсэн төлбөрт 37.4 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 9.7 тэрбум төгрөг, нийт 47.1 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 8.7 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант хугацааны эцэст төрийн өмчит нэр бүхий 13 байгууллагын 361.2 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан нь төрийн өмчит аж ахуйн нэгжид олгосон зээлийн авлагын 48.9 хувь, нийт өрийн 29.7 хувийг эзэлж байна.

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн 8.6 хувь буюу 32.5 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн байна.

Улс, орон нутгийн төсөвт болон төслийн 51 байгууллагын зээлийн авлага төлөгдөх хугацаа тодорхойгүй, 20 байгууллагын зээлийн авлагын төлөгдөх хугацаа 1-15 жилээр хэтэрсэн, 115 байгууллагын гэрээ байхгүйгээс 199.7 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг баталгаажуулаагүй байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг байгууллагаар үзүүлбэл:

(сая төгрөгөөр)

Зээлдэгч	Үндсэн төлбөр	Хүү төлбөр	Нийт дүн
Улаанбаатар төмөр зам ХНН	15,888.3	6,085.0	21,973.3
Багануур ХК	6,579.2	1,224.7	7,803.9
Шивээ-Овоо ХК	5,137.1	2,667.0	7,804.1
Дорнод бүсийн эр.хүч.систем ТӨХК	556.3	317.0	873.3
УБЦахилгаан түгээх сүлжээ ХК	1,229.8	346.7	1,576.5
Ховд ЦТС	0.0	110.2	110.2
Хөвсгөл-Эрчим хүч ХХК	48.0	79.7	127.7
Увс ЦТС	0.0	90.3	90.3
Даланзадгадын ДЦС ТӨХК	2,875.8	728.8	3,604.6
Диспетчерийн үндэсний төв	150.8	74.3	225.1
Дүн	32,465.3	11,723.7	44,189.0

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн хугацаа хэтэрсэн авлагын дундаж насжилт 6 жилд хүрсэн байна.

Засгийн газрын санхүүгийн тайланд олон жилийн турш бүртгэгдэж ирсэн 291.4 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах ажлыг “Шинэ эрин”, “Эрдэмт Төв” ТББ-тай хамтран гүйцэтгэж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эзэн холбогдогчгүй нийт 39.2 тэрбум төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэрийг үндэслэн данснаас хассан байна.

Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын дагуу БНХАУ-ын Засгийн газрын 300.0 сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газарт 2012 оноос эхлэн хэрэгжиж буй “Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өргөтгөл, шинэчлэл” төслийн хүрээнд 45,649.6 мянган ам.долларыг дамжуулан зээлдүүлэх төсөл хүчин төгөлдөр болсныг үндэслэн 2012 онд төслийн санхүүжилтэд 9.3 тэрбум төгрөг олгож, дамжуулан зээлийн авлагаар бүртгэсэн боловч МШХХТГ-аас шалтгаалан өнөөг хүртэл зээлийн гэрээ байгуулаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 55 дугаар захирамжаар БНХАУ-аас авсан зээлийн төслийг хэрэгжүүлэгч байгууллагаас 2002 оны эхний хагас жилд төлөх 816.7 сая төгрөгийн зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрт шинээр барьж ашиглалтад оруулсан 851.1 сая төгрөгийн өртөгтэй 40 айлын сууцны барилгыг төрийн өмчид хүлээн авахыг Санхүү, эдийн засгийн сайд /хуучин нэрээр/-д зөвшөөрчээ.

Дээрх орон сууцны үнээс Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 55, 2007 оны 32 дугаар захирамжаар нийт 25 иргэнтэй холбоотой 535.1 сая төгрөгийн авлагыг ямар нэгэн эрхийн актын үндэслэлгүйгээр чөлөөлж, гадаад зээлийн төлбөрийг барагдуулах эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна. Үлдэх 15 байгууллага, иргэнээс авах 316.0 сая төгрөгийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүйгээс Төв төрийн сангийн санхүүгийн тайланд олон жил дараалан авлагаар бүртгэгдэж иржээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Бондын эх үүсвэрээс олгосон зээлийн авлагын дансанд ЖДҮХСан, Мал хамгаалах сан, ОССК-тай холбоотой авлагыг бүртгэж, нийт дүнгээр 2012 оны эхэнд 358.3 тэрбум, оны эцэст 372.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Мал хамгаалах сангийн зардал санхүүжилтийг 2012 оны улсын төсөвт төлөвлөөгүй, санхүүгийн зээлээс санхүүжүүлэхээр тусгаснаас шалтгаалан ноос, ноолуур, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2011 онд тус сангаар дамжуулан мал бүхий иргэдэд ноосны урамшуулалд олгосон Засгийн газрын бондын санхүүжилтийн 9.8 тэрбум төгрөгийг авлагын дансанд бүртгэжээ.

Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн хуримтлалын сангийн эх үүсвэрээс ҮХААЯ-ны захиалгаар Төв аймгийн Угтаалцайдам сум дахь 36,000 тн багтаамжтай үр тарианы элеватор сэргээн засварлах ажлыг 3,667.8 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Сангийн яам, “Цаст Констракшн” компанийн хооронд 2012 оны 7 дугаар сард гэрээ байгуулсан байна.

Сангийн яамнаас гэрээний дагуу хийх санхүүжилт /нэмэлт зардлын хамт 3,957.2 сая төгрөг/-ийг “Цаст Констракшн” компанид шууд санхүүжүүлэн Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэлд Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалтын зардлаар тусган тайлагнасан боловч захиалагч

байгууллагын 2012 оны жилийн эцсийн аудит хийгдсэн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.

Дээрх гүйлгээний нөлөөгөөр ЗГСНТ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн орлого, зарлагыг ТЕЗ-дын аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлого, зарлагын дүнгээс 3.9 тэрбум төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

4.6 Төрийн өмчийн хорооны зарим шийдвэр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нийцэхгүй байна

2011-2012 онд ашиглалтад орсон нийт 13.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий зарим барилга байгууламжийг дуусаагүй барилга данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгээгүйгээс элэгдлийн зардал тооцогдохгүй байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 0.9 тэрбум, Дарханы дулааны цахилгаан станц 0.3 тэрбум, Диспетчерийн үндэсний төв 0.6 тэрбум сая төгрөгөөр тус тус бууруулсан бол “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 0.3 тэрбум төгрөгөөр илүү тооцоолж, “Дулааны III цахилгаан станц” ТӨХК ашиглалтгүй үндсэн хөрөнгөнд 0.4 тэрбум төгрөгийн элэгдэл байгуулж, зардлыг нэмэгдүүлсэн байна.

ТӨХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин төрийн өмчийг төрийн бус байгууллагад шилжүүлэх, байгууллагаас ирүүлсэн мэдээллийг өөрчлөн хөрөнгийг үнэгүйдүүлэх шийдвэрийг гаргасан байна. Тухайлбал,

- ТӨХ-ны 2012 оны 75 дугаар тогтоолоор 2008 онд ашиглалтад орсон нэг бүр нь 24.7 сая төгрөгийн анхны үнэтэй “Соната-6” маркийн 2 автомашиныг элэгдлийг нэмэгдүүлэн, үлдэх өртгийг бууруулж, нийт 14.4 сая төгрөгөөр Санхүүгийн зохицуулах хорооноос “Албан журмын даатгагчдын холбоо” ТББ-д балансаас балансад шилжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.2-т заасныг зөрчсөн байна.
- Газрын тосны газар 2008 онд ашиглалтад орсон, 15.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Ниссан тиана автомашиныг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрлийг ТӨХ-ноос хүссэн байна. Гэтэл ТӨХ-ны 2012 оны 407 дугаар тогтоолд дээрх мэдээллийг 2004 онд ашиглалтад орсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй гэж өөрчлөн тусгаж, 2.0 сая төгрөгөөр дуудлага худалдаагаар зарах шийдвэр гаргажээ.
- ТӨХ-ны 2012.01.25-ны 16/143 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрөл, “Мон атом” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2012 оны 1 дүгээр сарын 31-нд “Эрдэнэс МГЛ” ХХК-иас “Мон атом” ХХК-д сарын 0.5 хувийн хүүтэй, 300.0 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан олгожээ. Гэрээний хугацаа дууссан боловч “Мон атом” ХХК зээл, зээлийн хүүг эргэн төлөөгүй, тайлант оны жилийн эцсийн байдлаар 348.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

4.7 Төрийн сан дахь НДС-ийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд хүү төлөгдөхгүй байна

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн банкин дахь харилцах дансны үлдэгдлийг байршлаар нь харуулбал:

(сая төгрөгөөр)

Мөнгөний байршил	Мөнгөн хөрөнгийн		Хүүгийн орлого		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Харилцахын хүү	Хадгаламжийн хүү	Нийт дүн
Төрийн сан	115,290.6	114,017.4	-	-	-
Арилжааны банк	286,359.5	299,908.4	10,012.7	9,942.8	19,955.5
Нийт дүн	401,650.1	413,925.8	10,012.7	9,942.8	19,955.5

Хүснэгтээс үзвэл, сангийн нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 27.5 хувийг нийгмийн даатгалын сангуудын төв, орон нутгийн төрийн сан дах мөнгөн хөрөнгийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд дээрх хөрөнгөд хүү тооцогдохгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11.3-т “Хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн газрын бонд болон Монголбанкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болно” гэж заасантай нийцэхгүй, сангийн хөрөнгө үнэгүйдэх эрсдэлээс хамгаалагдахгүй байна.

4.8 Хүний хөгжил сангийн санхүүгийн тайлан 1,057.8 тэрбум төгрөгийн алдагдалтай тайлагнагджээ

ХХС-ийн 2012 оны санхүүгийн тайлангаар 9.3 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 1,067.1 тэрбум төгрөгийн өглөгтэй, 1,057.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Сангийн өглөг оны эхэнд 686.8 тэрбум төгрөг байснаас 693.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 252.9 тэрбум төгрөгөөр хорогдож, оны эцэст 1,067.1 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнд:

- Оюутолгойн 115.0 сая ам.долларын хөнгөлөлттэй бондын өглөг 151.7 тэрбум төгрөг,
- Оюутолгой ХХК-иас урьдчилгаа төлбөрт авсан 150.0 сая ам.доллар буюу 193.7 тэрбум төгрөг,
- “Эрдэнэс МГЛ” ХХК-иас авсан урьдчилгаа төлбөрийн өглөг 399.3 тэрбум төгрөг,
- Засгийн газрын бондын өглөг 313.1 тэрбум төгрөг,
- Иргэдэд олгох хишиг хувийн 9.3 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүний хөгжил сангийн орлогыг бүрдүүлж, зарлагыг санхүүжүүлсэн дээрх хүүтэй урьдчилгаа, зээл, бондын эх үүсвэрийн холбогдох гэрээ хэлэлцээрт заасны дагуу тайлант хугацаанд ноогдох хүүгийн зардал, ханшийн зөрүүгийн ашиг, алдагдлыг НББ-ийн аккрузэл сууриар тооцож, бүртгэлд тусгаагүй байна.

Хүний хөгжил сангийн орлогыг дээрх байдлаар зээл, урьдчилгаа тооцоогоор бүрдүүлсэн нь өрийн болон хүүгийн давхар дарамтыг бий болгосон байна. Тухайлбал,

- “Эрдэнэс МГЛ” ХХК Хүний хөгжил санд орлого төвлөрүүлэхдээ охин компани болох “Эрдэнэс Тавантолгой” ХХК-иас, “Эрдэнэс Тавантолгой” ХХК нүүрс худалдан авах гэрээ байгуулсан БНХАУ-ын Чалко компаниас урьдчилгаа төлбөрөөр 287.0 тэрбум төгрөг, дотоодын банкнаас 129.0 тэрбум төгрөгийн зээл авч төвлөрүүлжээ. Үүнтэй холбоотойгоор тус компани Чалко компани болон банкинд төлөх хүүгийн төлбөр 34.2 тэрбум,

валютын ханшийн зөрүү 24.6 тэрбум, нийт 58.8 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК 2012 онд Хүний хөгжил санд төвлөрүүлсэн 110.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн эх үүсвэрийг “Ocean Partners UK Ltd” компаниас авсан 110.0 сая ам.долларын хүүтэй зээлээс төлсөн байна.

Тав. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийж, 481.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 117.4 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өглөө.

Тайлант хугацаанд төсвийн 35 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, 80 хувь буюу 28 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт, 20 хувь буюу 7 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдад санал дүгнэлт өгсөн байдлыг өмнөх онтой харьцуулахад “зөрчилгүй” санал дүгнэлтийн хувийн жин 13 пунктээр буурч, “хязгаарлалттай” санал дүгнэлтийн хувийн жин тэр хэмжээгээр өсчээ.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн зарим батламж мэдэгдэлтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчлүүд илэрсэн нь зарим Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2012 оны санхүүгийн тайланд өгөх санал дүгнэлтийг хязгаарлахад хүргэлээ. Үүнд:

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлан	“Хязгаарлалттай” санал дүгнэлтийн шалтгаан
1	Батлан хамгаалахын сайдын 2012 оны төсвийн багц	Барилга захиалагчийн алба санхүүгийн тайландаа ҮАГ-аас хуваарилсан “Энич” ХХК-аар хийлгэхээс татгалзаж өөр компаниар аудит хийлгэсэн, Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн тайлан тэнцэлд урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн 2,716.3 сая төгрөгийг хувь хүний хадгаламжийн дансанд байршуулж байсан бөгөөд уг хөрөнгийн эх үүсвэр, зориулалт тодорхойгүй, өр авлагын тооцоо нийлээгүй;
2	Эрүүл мэндийн сайдын 2012 оны төсвийн багц	Эрүүл мэндийг дэмжих сангаас гэрээ байгуулж, ААН байгууллагуудад олгосон 581.4 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг аудит хийх хуулийн хугацаанд ирүүлээгүй, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн харьяа “Аварга тосон” эмчилгээний тасгийн орлого, зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд тусгаагүй;
3	Хууль зүйн сайдын 2012 оны төсвийн багц	ЦЕГ-ын гэрээт албаны 2012 оныг хүртэл хугацааны санхүүгийн тайланг Хууль зүйн сайдын төсвийн багцын санхүүгийн тайланд нэгтгэж, бүртгэлээр тавих ТЕЗ-ын хяналтыг хэрэгжүүлж байгаагүй, 2012 оны тайланд нэгтгэсэн хэдий ч тус албаны тайлангийн эхний үлдэгдлийн мөнгөн хөрөнгийн 597.7 сая төгрөг, авлагын 178.4 сая төгрөг, бараа материалын 14.5 сая төгрөг, өр төлбөрийн 270.0 сая төгрөг, хуримтлагдсан үр дүнгийн 520.7 сая төгрөгийг аудитаар баталгаажуулах боломжгүй;

4	Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны төсвийн багц	Санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,010.9 сая төгрөгийн, 5 төслийн тайлан ирээгүй байхад нэгтгэсэн, 4 төслийн банкин дахь 16.7 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, Барилгын хөгжлийн төвийн 2012 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх үлдэгдлийг банкин дахь харилцах дансны хуулгын үлдэгдлээс 48.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Нийтийн тээврийн автобусны үнийн эргэн төлөлтөөс сан бүрдүүлэх 60.1 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг, алдагдлын дансанд бүртгэж өглөг бууруулсан, ОССК тайлант оны эцэст 14,502.2 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй;
5	Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2012 оны төсвийн багц	Нийт 8,767.0 сая төгрөгийн хөрөнгийг тусгаагүй орхигдуулсан;
6	Соёл, спорт аялал жуулчлалын сайдын 2012 оны төсвийн багц	Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад тайлан удаа дараа засагдсан боловч санхүүгийн байдлын, үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн тайлан болон тодруулгууд нь хоорондоо материаллаг хэмжээний зөрүүтэй илэрхийлэгдсэн;
7	Сангийн сайдын 2012 оны төсвийн багц	Гадаад зээлийн ашиглалтын төлөвлөлтөөс шалтгаалан батлагдсан төсвийг 15,045.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Дээрх төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн мөнгөн хөрөнгийг хувь хүний хадгаламжийн дансанд байршуулсан, өр авлагын тооцоо нийлээгүй, харъяа байгууллагынхаа орлого, зарлагын гүйлгээг санхүүгийн тайланд тусгаагүй, бүртгэлээр тавих ТЕЗ-ийн хяналтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан дахь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг аудитаар баталгаажуулах боломжгүй, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан зэрэг алдаа, зөрчил илэрснээс 2012 оны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгчээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 75 зөвлөмж өгснөөс 80.0 хувь нь бүрэн хэрэгжиж, 5.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 14.7 хувь нь хэрэгжих шатандаа байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй төсвийн ерөнхийлөн захирагчид:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Хэрэгжих шатандаа	Хугацаа хэтэрсэн
Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багц	3	
УИХ-ын даргын төсвийн багц		1
Сангийн сайдын төсвийн багц	1	
БШУСайдын төсвийн багц		1
ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргын төсвийн багц	1	
Улсын ерөнхий прокурорын төсвийн багц	1	
Эрүүл мэндийн сайдийн төсвийн багц	1	
Зам тээврийн сайдын төсвийн багц		1
Батлан хамгаалахын сайдын төсвийн багц	2	1
Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багц	1	
Хүний хөгжил сан	1	
Дүн	11	4

Аудитын зөвлөмжийн биелэлтийн мөрөөр хийсэн шалгалтаар зарим Төсвийн ерөнхийлөн захирагч зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, ажил зохион байгуулаагүй байна. Тухайлбал,

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багц 2012 оны эхний хагаст багтаан Барилга захиалагчийн ажлын албаны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх асуудлыг судалж, бүтцийг холбогдох хууль тогтоомжийн дагуу оновчтой зохион байгуулах,
- Батлан хамгаалахын сайдын төсвийн багц байгууллага, хувь хүнээс авах авлага, өр төлбөрийг барагдуулах,
- Улсын Их Хурлын даргын төсвийн багц УИХ-д суудалтай улс төрийн намуудад улсын төсвөөс олгох дэмжлэгийг аль Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцаар дамжуулан олгох асуудлыг Сангийн яамтай хамтран шийдвэрлэж, тус байгууллагад хамаатай ажил гүйлгээ, үйл явдал, тухайн хугацаанд тохиолдсон байх батламж мэдэгдлийг мөрдөж ажиллах,
- Зам тээврийн сайдын төсвийн багц яамны ажилтнуудын гадаад томилолтын болон орон сууцны дэмжлэг, бусад зардлыг харъяа байгууллагаас гаргуулахгүй байхаар арга хэмжээ авч ажиллах зэрэг зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

ТЕЗ-дын 2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 106 зөвлөмж өгснөөс хариуцлагыг сайжруулах 28.3 хувь, төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулах 23.6 хувь, үр нөлөөг сайжруулах 15.0 хувь, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 12.3 хувь, үр ашгийг дээшлүүлэх 11.3 хувь, нягтлан бодох бүртгэлийг сайжруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 9.5 хувийг эзэлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын санал дүгнэлт, илрүүлсэн алдаа, тайлан гаргаж ирүүлсэн хугацаа, зөвлөмжийн мэдээг А-1, А-2 хавсралтаар үзүүлэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 22 байгууллагад 6.4 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 36 байгууллагад 254.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өглөө.

Зургаа. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар

Аймаг, нийслэлийн аудитын газраас орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийж 259.8 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 26.5 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 107 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн 16 тайланд зөрчилгүй, 6 тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгч 1.2 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 13.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага бичжээ.

№	“Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан орон нутгийн ТЕЗ	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Баян-Өлгий аймгийн ТЕЗ	• Батлагдсан төсвийн зарлагыг нийт дүнгээр 339.5 сая төгрөгөөр буюу 4.5 хувиар хэтрүүлэн зарцуулсан
2	Дундговь аймгийн ТЕЗ	• Орон нутгийн 35 байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн 18 буюу

		51.4 хувь нь “Зөрчилгүй”, 5 буюу 14.3 хувь нь “Хязгаарлалтай”, 11 буюу 31.4 хувь нь “Сөрөг”, 1 буюу 2.9 хувь нь “Татгалзсан” дүгнэлттэй гарснаас гадна өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 20 хувийг хэрэгжүүлээгүй.
3	Говьсүмбэр аймгийн ТЭЗ	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, тэтгэвэрт гарахад олгох санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, шагнал урамшууллыг хавтгайруулан олгосон
4	Сэлэнгэ аймгийн ТЭЗ	<ul style="list-style-type: none"> Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.3 тэрбум төгрөгөөр буюу 56.9 хувиар тасалсан, аймгийн Төрийн сан 1,229.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, Сумдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг 485,6 сая төгрөгийн зөрчил илэрсэн
5	Увс аймгийн ТЭЗ	<ul style="list-style-type: none"> Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг зөрчин аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор орон нутгийн төсөвт тодотгол хийж батлагдсан төсөвт зардлыг нийт 242.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн,
6	Нийслэлийн ТЭЗ	<ul style="list-style-type: none"> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг зөрчиж 297.1 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 25.8 сая төгрөгийн авлага, 151.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэл дутуу 107.9 сая төгрөгийн гүйлгээг хийсэн, 351.7 сая төгрөгийн гүйлгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн зэргээр нийт 1,703.2 сая төгрөгийн зөрчил гаргасан.

Орон нутгийн ТЭЗ-дын 2011 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 171 зөвлөмж өгснөөс 69.6 хувийг бүрэн хэрэгжүүлж, 11.7 хувь нь хэрэгжих шатандаа, 18.7 хувь буюу 32 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Долоо. ТӨААН-үүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитын талаар

ҮАГ-аас Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу хараат бус аудитын 30 компанитай гэрээ байгуулан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 87 аж ахуйн нэгжийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийж, 53 буюу 60 хувьд “зөрчилгүй”, 31 буюу 36 хувьд “хязгаарлалттай”, 2 буюу 2 хувьд “сөрөг дүгнэлт”, 1 буюу 1 хувьд “дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өгсөн байна. Гэрээгээр аудит хийлгэсэн санхүүгийн тайланд өгсөн санал дүгнэлтийг харуулбал:

Аудитын санал дүгнэлтийн хэлбэр	Байгууллагын тоо
Зөрчилгүй	53
Хязгаарлалттай	31
Сөрөг	2
Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	1
НИЙТ ДҮН	87

Санхүүгийн тайланд нь “**Хязгаарлалттай**” санал дүгнэлт өгөгдсөн байгууллагууд:

д/д	Байгууллага, ААН-ийн нэр	Санал, дүгнэлтийн үндэслэл
1	Авто замын тоног төхөөрөмжийн түрээс ТӨХК	Засгийн газраас хүлээн авсан 13,660.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнгээр хувьцаат капиталын төрийн өмчийн хэсгийг нэмэгдүүлсэн, нүүрсний үнийн зөрүү болох 500.0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, ханшийн зөрүүний орлогыг шууд өмчийн хэсгийн хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлэн тооцсон, нийт худалдан авалтын 79.9 хувь буюу 15.3 тэрбум төгрөгийн бараа материал, 5.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг тендер

		зарлахгүйгээр худалдан авалт хийсэн, 993.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨХ-ны тогтоолгүйгээр акталж хассан
2	Багануурын Дулааны станц	ҮТЕГ-ын Маргаан таслах зөвлөлд хандсан татварын шийдвэрлэгдээгүй асуудлаас үүсч болзошгүй өр төлбөр өндөртэй
3	Бөртэ ТӨҮГ	2012 оны 12 дугаар сарын сүүлчээр ЦЕГ-аас 218.4 сая төгрөг, УЕПГ-аас 181.9 сая төгрөг, ЗХЖШ-аас 56.8, нийт 557.2 сая төгрөг /төсвийн байгууллагуудаас/ хувцас захиалгын үнэнд шилжин ирснээс өглөг өмнөх оноос 3.8 дахин өссөн байна
4	Булган АЗЗА ТӨХК	Бетон хоолойн ажлыг гүйцэтгүүлэхээр “Од-Мөнх” ХХК-д 38.4 сая төгрөг шилжүүлсэн боловч өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн, хяналтын тооллогоор 2.8 сая төгрөгийн бараа материал дутсан, 1.1 сая төгрөгийн хандив өгсөн.
5	Дарханы ДЦС ТӨХК	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцохдоо 328.0 сая төгрөгөөр дутуу тооцон тайлагнажээ.
6	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	Гадаад валютаар хийгдсэн 4,322.5 сая төгрөгт ханшийн тэгшитгэл хийгээгүй, байгууллага хоорондын авлага 2,764.5 сая төгрөг, өглөг 4,624.0 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй
7	ДБУААЭГ УТҮГ	Олон жил дамжуулан тайлагнаж байгаа 214.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй
8	Дорноговь АЗЗА ТӨХК	Дэлхийн банкны зээлээр олгосон 119.1 сая төгрөг, Кувейтын сангийн зээлээр 176.4 сая төгрөг, нийт 295.5 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөгтэй гарсан байна. НББ-ийн журналууд хөтлөөгүй байна.
9	Дорнод бүсийн эрчим хүчний систем ХК	Үндсэн хөрөнгийн элэгдлийг санхүүгийн програмаар бодож гаргасан дүнгээс 915.1 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн, 386.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн.
10	Дулаан шарын гол ХК	ДСЦТС ХК-тай авлага өглөгийн тооцоо нийлсэн акт байхгүй байсныг тулган шалгахад ДСЦТС-ийн бүртгэлээр 4.0 сая, өөрийн балансаарх дүнгээс 202.7 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.
11	Дулааны III цахилгаан станц ТӨХК	Олон жил дамжуулан тайлагнаж байгаа 4,124.7 сая төгрөгийн авлага, 3,869.8 сая төгрөгийн шагналт цалингийн зардал, ашиглалтгүй байгаа хугацаанд нь байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 434.0 сая төгрөг, ажиллагсдын нийгмийн хамгааллын зардал 981.1 сая төгрөгөөр ББӨ-ийг нэмэгдүүлэн тайлагнасан.
12	МИАТ ХК	Агаарын тээврийн өр дансны үлдэгдэл нь програм солих явцад алдаа гарч их хэмжээний зөрүү үүссэн, үндсэн хөрөнгөд “тэг” үлдэгдэлтэй болон зах зээлийн үнээс хэт доогуур үнэтэй үндсэн хөрөнгүүдтэй, найдваргүй авлагын нөөц тооцож боддоггүй, агаарын тээврийн татвар бодитой эсэх нь тодорхой бус, батлагдсан төсвөөс 9.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.
13	Мон Атом ХХК	Тайлант онд төлөвлөж буй ашиг алдагдлаа ТӨХ-р батлуулаагүй, 418.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж хуримтлагдсан алдагдлын хэмжээ 1,197.9 сая төгрөгт хүрсэн, 2010-2012 онуудад зөвхөн банкны зээлээр үйл ажиллагаагаа явуулж өр төлбөрийн хэмжээ урьд оноос 1.8 дахин өсч 2,035.1 сая төгрөгт хүрсэн.
14	Монгол кино нэгтгэл ТӨҮГ	2,345.5 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримт нотолгоо хангалтгүй байна
15	Монгол цэрэг жуулчин компани	Хөрөнгө оруулалтын 400.0 сая төгрөгийн тооцоо, орлогыг бүртгэж тайлан тэнцэлд тусгаагүй
16	Монголын хөрөнгийн бирж ХК	ТӨХ-оос баталсан эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг 1,165.8 сая төгрөгөөр тасалж алдагдалтай ажилласан, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй
17	Монголын ЦХ ХК	Тайлант онд дансны авлага 191.5 сая төгрөгөөр, бусад авлага 578.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, найдваргүй авлагын дүн 871.7 саяд хүрсэн байна. Батлагдсан төсвөөс 367.1 сая төгрөгийн зардал хэтрүүлсэн байна
18	Монсам ХХК	336.9 сая төгрөгийн авлага нь нийт хөрөнгийн 27%-ийг эзэлж байна. Авлагын тулган баталгаажуулалт хийгээгүй бөгөөд 293.6 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан
19	Оргил рашаан сувилал	Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвд тус сувиллын 247.3 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй ашиглуулж байна.
20	Тамга тэмдгийн үйлдвэр ТӨҮГ	Санхүүгийн тайлангаар 47.9 сая төгрөгийн өглөгтэй гарсан, 32.8 сая төгрөгийн шагнал урамшуулалд НДШ тооцоогүй зөрчлүүд илэрсэн ба тайланг санхүүгийн програмаар гаргаагүй учир балансын бүх үзүүлэлтийг

		тулгаж гарч болох эрсдэлийг нягтлан шалгах боломжгүй байсан
21	Төлбөр хураах цэг	Цалин болон НДШ-ийн зардлын тооцоог мөнгөн сууриар бэлтгэсэн зөрчил илэрсэн
22	Төрийн банк ХХК	Тогтоол шийдвэргүйгээр 540.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг, 20500 ам долларын сургалтын төлбөр, 10 сая төгрөгийн эмчилгээний зардал олгосон байна
23	УБЦТС ТӨХК	Үндсэн хөрөнгийг 171,033.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан бөгөөд үндсэн хөрөнгийг ангилж программ хангамж, бүртгэлд тусгасан байдал зөрчилтэй, Дуусаагүй барилга 8,252.6 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч бүртгэл, хяналт, тайлагнал нь баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол нь СТОУС-ын шаардлагад нийцэхгүй байна. 125.6 сая төгрөгийн шагнал урамшууллыг олгосон байна.
24	Цагаан шонхор ТӨҮГ	2.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулаагүй, журнал болон ерөнхий дэвтэр хөтлөөгүй
25	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ	Баталсан төсвийг 5.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн
26	Шивээ-овоо ХК	Охин компани Шивээ сервис ХХК-ийн тайланг 2012 оны тайланд нэгтгээгүй, СЯ-ны зөвшөөрөлгүй програм ашигладаг, үндсэн хөрөнгийн элэгдлийн 126.0 сая төгрөгийн алдааг буруу залруулж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн
27	Эрдэнэс таван толгой ХК	31.9 тэрбум төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг хамтарсан концерциумын охин компанид шилжүүлэхээр тохирсон ч ТӨХ-ны шийдвэргүйгээс шилжүүлээгүй тул 26.6 тэрбумын өглөг, 31.9 тэрбум төгрөгөөр хөрөнгө буруу илэрхийлэгдсэн, Компаний хэрэгцээнд тохирохгүй 3,676.5 сая төгрөгийн өртөгтэй 30 ш дугуй, 1,650.0 сая төгрөгийн дансны үнэтэй 10 ш автосамосвалаас компани үнийн бууралтын алдагдал хүлээх эрсдэлтэй байна. Засгийн газрын 2012.04.11-ний 116 дугаар тогтоолоор иргэн бүрт 1.5 сая төгрөг олгох арга хэмжээний хүрээнд компанийн нийт хувьцааны 20 хүртэлх хувийг эзэмшүүлэхээр заасан. Гэвч компанийн НББ-д энэ хувьцааг бүртгээгүй байна
28	Эрдэнэт Булганы ЦТС ТӨХК	Тайлант жилийн алдагдал 2.3 тэрбум төгрөгийг тушаал шийдвэргүйгээр хаасан, эзэмшигчийн өмчийн дүн холбогдох шийдвэр, улсын бүртгэлээс 406.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
29	Эрдэнэтийн ДЦС ТӨХК	Татварын ерөнхий газрын шалгалтаар 373.2 сая төгрөгийн акт тогтоосон ба уг актыг компаний удирдлага хүлээн зөвшөөрөөгүйгээс шүүхээр шийдвэрлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна
30	Эрчим корпораци	ТӨХ-ны шийдвэргүйгээр 3 ажилтанд 24.6 сая төгрөгийн урамшуулал олгосон
31	Эрчим хүчний хөгжлийн төв УТҮГ	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 80.7 сая төгрөгийн 2 автомашин бодитоор байхгүй болон урт хугацаат зээлийн үлдэгдэл, дуусаагүй үйлдвэрлэлийн 68.4 сая төгрөгийн зөрүүг тогтоох боломжгүй

“Сөрөг” болон “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

д/д	Байгууллага, ААН-ийн нэр	“Сөрөг” санал дүгнэлтийн шалтгаан
1	Баруун бүсийн эрчим хүчний систем	Тус компаний охин компаниуд НББ-ийн бодлого тууштай баримталдаггүй, Барилга тоног төхөөрөмжийн дүн нийлээд балансын 33%-ийг эзэлж байгаа нь үл хөдлөх хөрөнгийн татвар элэгдлийн нөлөөлөл ихтэй байна, Төсвөөс санхүүжүүлсэн алдагдал бууруулах санхүүжилтээс НӨАТ суутгадаггүй нь эрсдэлтэй байна. Аудитаар өгсөн НББ-ийн залруулгыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч өөрчлөлт хийгээгүй.
2	Багануур ХК	Засгийн газраас хүлээн авсан 13,660.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнгээр хувьцаат капиталын төрийн өмчийн хэсгийг нэмэгдүүлсэн, Нүүрсний үнийн зөрүү болох 500.0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй.

“Дүгнэлт өгөхөөс татгалзсан” шалтгаан

1	Транс сэргэлт ТӨААТҮГ	Үйлдвэрийн газрын харилцах данснаас дэд захирал Н.Наран-Очирын хувийн харилцах дансаар 1,395.6 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийсэн. НББ-ээ MS Excel програмаар хөтөлж байсан гэх ба мөнгөн хөрөнгө, цалингийн бүртгэлээс бусад бүх файл устсан шалтгаанаар НББ-ийн журналуудыг аудитад хамруулаагүй.
---	--------------------------	--

Гэрээгээр хийлгэсэн аудитаар 2.7 тэрбум төгрөгийн алдааг залруулан, зөрчил дутагдлыг арилгах 374 зөвлөмж өгч, 3.7 тэрбум төгрөгийн албан шаардлага, 0.7 тэрбум төгрөгийн төлбөр барагдуулах акт бичсэн байна.

Төрийн өмчит ААН-ийн 38 байгууллага 2012 оны санхүүгийн тайлангаар нийт 48.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн ТУЗ-ийн хурал тухайн хуулийн этгээдийн өмнөх хугацааны тайланг хэлэлцэн дүгнэх, төсөв төлөвлөгөөг батлах төдийгөөр хязгаарлагдаж, гаргаж буй тогтоол, шийдвэрийн дийлэнхийг бүтэц, зохион байгуулалт, цалин тогтоох, удирдлагыг томилох, чөлөөлөхтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн нь түгээмэл байна. Тухайлбал, “Эрдэнэс-МГЛ” ХХК-ийн ТУЗ тайлант онд 9 удаа хуралдаж, 23 тогтоол гаргаснаас 6 нь компанийн ажлын төсөв төлөвлөгөө, тайланг дүгнэх, гэрээ байгуулах зөвшөөрөл олгох зэрэг үйл ажиллагаатай холбоотой, 17 нь компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох, чөлөөлөх, ТУЗ-ийн даргыг томилох, охин компанийн ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох зэрэг асуудлыг тусгажээ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 21.4-т “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно” гэж заасныг зөрчин ТУЗ-ийн зарим гишүүн төрийн албан хаагч нар аж ахуйн нэгжээр гар утас, шатахууны зардал төлүүлж, орон сууцны хөнгөлөлт, шагнал урамшуулал авсан байна. Тухайлбал, Төрийн банкны ТУЗ, Хяналтын зөвлөлийн дарга нарын гар утасны ярианы төлбөрт 1.3 сая төгрөг, нэр бүхий 11 гишүүний урамшуулалд нийт 153.4 сая төгрөг, 6 гишүүнд орон сууцны хөнгөлөлтөд 540.0 сая төгрөг, “МИАТ” ТӨХК-ийн ТУЗ-ийн даргын унаа, гар утасны нэмэгдэлд 3.8 сая төгрөг тус тус зарцуулж, “Эрдэнэс Тавантолгой” ХХК Хяналтын зөвлөлийн 3 гишүүнд нэг бүр нь 1.1 сая төгрөгийн үнэ бүхий “iPhone-4” гар утас, ТӨХ-ны ажилтанд 0.9 сая төгрөгийн үнэ бүхий “iPhone-4” гар утас, 1.0 сая төгрөгийн үнэ бүхий “iPad” зэргийг авч өгчээ.

Зарим ТӨААН бүртгэлийн стандарт зөрчин өртөг, зардалд тооцогдохгүй зардлуудыг бүртгэх, алдагдлыг ихэсгэх, багасгах бичилтийг хийжээ. Тухайлбал,

- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв: ТӨХ-ны 2012 оны 260 дугаар тогтоол болон захирлын тушаалаар байгууллагын захирал, түүний удирдлагын багийн гишүүдэд 15.7 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2012 оны 6 дугаар тогтоолоор “Компанийн ажилтанд орон сууцны дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн, орон сууцны асуудлаа шийдвэрлэхэд олгох буцалтгүй тэтгэмжийн дээд хэмжээг 15.0 сая төгрөг байхаар баталсан байна. Гэвч ТУЗ-ийн 2012 оны 13 дугаар тогтоолоор компанийн дэд захиралд 60.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг олгосныг тус тус тайлант үеийн зардлаар бус өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнг бууруулан тайлагнасан байна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ НББОУС болон нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөөгүй байна

Эрдэнэт үйлдвэр ХХК санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ НББОУС 27, НББОУС 28-д заасны дагуу охин компаниудынхаа санхүүгийн тайланг нэгтгээгүй, хараат компаниуддаа оруулсан хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэж тайлагнаагүй байна.

Эрдэнэт үйлдвэрт мөнгөн хөрөнгийн хомсдол бий болсон тул “Ocean partners UK Limited” компаниас 110.0 сая ам.долларын, Ростехнологи Төрийн өмчийн корпорациас 45.0 сая ам.долларын зээл авч хөрөнгө оруулагчдын ногдол ашиг төлөхөд зарцуулсан байна.

“Ocean partners UK Limited” компаниас авсан дээрх 110.0 сая доллар буюу 221,812.3 сая төгрөгийн зээлийн төлбөрийг урьдчилж орсон орлого дансаар бүртгэж богино хугацаат өр төлбөрийн ангиллыг буруу илэрхийлжээ.

Монголросцветмет ХХК урьд онд илүү тооцоолсон элэгдлийн зардлыг залруулахдаа хөрөнгийн дахин үнэлгээ дансанд бүртгэснээс гадна Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол болон ААНОАТ-ын тухай хуульд заасан элэгдлийн хувь хэмжээний зөрүүтэй холбогдон гарах өнөөгийн болон ирээдүйн татварын нөлөөллийг НББОУС 12-т заасны дагуу бүртгэлд тусгаагүй байна.

Багануур ХК Засгийн газраас эрчим хүчний байгууллагуудын алдагдлыг бууруулах зорилгоор олгосон 500.0 сая төгрөгийн татаасын орлогыг орлогоор хүлээн зөвшөөрөлгүй өмнөх үеийн алдагдлыг бууруулах бичилт хийсэн, түрээсээр эзэмшдэг Белаз 7555В маркийн автомашины сүүлийн 2 сарын түрээсийн төлбөр болох 315.0 сая төгрөгийг аккруэл сууриар бүртгээгүй, зээлээр авсан тоног төхөөрөмжийн 108.0 сая төгрөгийн хүүгийн зардлыг буруу бүртгэжээ.

Эрдэнэс Тавантолгой ХХК 6,075.4 сая төгрөгийн орлогын албан татварын зардал болон өглөгийг бүртгэлд тусгаагүйгээс цэвэр ашиг илүү, татварын өр дутуу илэрхийлэгдсэн байна.

Тус компани Хөгжлийн банкнаас авсан 100.0 сая ам.долларын зээлийг нөхөн сэргээлтийн нөөцтэй хамтатган бүртгэжээ. Мөн гадаад валютаар авсан зээлийн тайлангийн эцсийн үлдэгдлийг хаалтын ханшаар тэгшитгээгүйгээс 524.0 сая төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүгийн алдагдал дутуу бүртгэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн удирдлагын талаар

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 7,705.7 сая төгрөг, авлага 28,974.0 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 193,399.9 сая төгрөг, урт хугацаат өр төлбөр 6,063.6 сая төгрөг, ерөнхий болон удирдлагын зардал 47,470.9 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбогдон мөнгөн хөрөнгийн зохистой харьцаа алдагдаж төлбөрийн чадвар муудсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын худалдан авалтын талаар

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн бараа материал, үндсэн хөрөнгийн нийлүүлэлтийг үйлдвэрийн ОХУ-ын талын хувь эзэмшигч Ростехнологийн охин компани LAOAG Technical & metallurgical services LTD компани нийлүүлж байна.

Компанийн тухай хуулийн 89.1-д заасны дагуу эдгээр компаниуд сонирхлын зөрчилтэй бөгөөд хуулийн 89.5-д “Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэж заасан боловч холбогдох мэдээллийг жилийн тайланд тусгаагүй байна.

Мөн 2012 онд ОХУ-ын талын хувь эзэмшигч Ростехнологийн саналын дагуу “Stock International GmbH, Minerals and Metals Group” Ltd, Metallic Impex Corp компаниудтай сонгон шалгаруулалтгүйгээр 24.3 сая ам.долларын гэрээ хэлцлүүдийг хийжээ. Дээрх компаниудын нийлүүлсэн үндсэн хөрөнгө аудитын багийн хийсэн цахим хуудсаарх үнийн судалгаагаар 10,747.6 сая төгрөгийн өндөр үнэтэй байна.

Тус үйлдвэрт 2012 онд гэрээний дагуу ган бэлдэц нийлүүлсэн МҮХК ХХК, Эс Си Эм ХХК, Аж богд трейд ХХК-ийн үнийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрээс худалдан авсан үнэтэй харьцуулан үзэхэд 7,776.9 сая төгрөгөөр илүү байна.

Эрдэнэт үйлдвэрийн 2012 онд хийгдсэн ган бөмбөлгийн бэлдэцийн захиалгын дүнгийн 44 хувийг Minerals & metals group (PTE) LTD компанитай ямар нэг сонгон шалгаруулалтгүйгээр 1 тн-ыг нь 1100 ам.доллараар тооцон 12.0 мянган тн буюу 13.2 сая ам.долларын Ф80 ган бөмбөлгийг харьцангуй өндөр үнээр нийлүүлэх гэрээ байгуулжээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг зөрчжээ.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК бэлтгэн нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй байхад хариуцлага тооцоогүй байна. 2012 онд 300,000 ам.доллар буюу 417.6 сая төгрөгөөс дээш бараа материал нийлүүлсэн бэлтгэн нийлүүлэгчдийг түүвэрлэн шалгахад нийт 29 аж ахуйн нэгж 21,6 тэрбум төгрөгийн бараа, материалыг хугацаа хоцроож нийлүүлсэн боловч гэрээний хариуцлага тооцоогүй байна.

Багануур ХК 15.3 тэрбум төгрөгийн бараа материал, 5.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө, Эрдэнэс Тавантолгой ХХК 222.9 сая төгрөгийн бараа материал, 1,390.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус тендер зарлалгүй бэлтгэсэн байна.

Эрдэнэс Тавантолгой ХХК тендер зарлан Юу Эс Трейд ХХК-ийг шалгаруулсан боловч тус компанийн нийлүүлсэн 3,676.5 сая төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг дугуй чанарын шаардлага хангаагүйгээс ашиглагдахгүй байна.

Багануур ХК-ийн сэлбэг бараа материалын 21.3 хувь буюу 4.8 тэрбум төгрөгийн бараа материал ашиглагдахгүй байгаа бөгөөд үүнээс 318.1 сая төгрөгийн хөрөнгө нь актлах шаардлагатай болсон байна.

Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний талаар

Эрдэнэт үйлдвэр ХХК 2011 онд ашигт малтмалын нөөц ашигласны татварт 5,532.0 сая төгрөгийг дутуу төлсөн хэмээн нөхөн төлүүлэхээр тогтоосон төлбөрийн актын үндэслэлийг шалгуулж татварын зөвлөх үйлчилгээ авахаар тус компани ЮС ХХК-тай байгуулсан гэрээний дагуу татвар илүү хураасан асуудлыг Татварын байгууллагааар шийдвэрлүүлсэн тул асуудлын үнийн дүнгийн 12.5 хувь буюу 691.0 сая төгрөгийг зөвлөх компанид олгох болжээ. Татвар төлүүлэхээр тогтоосон актыг

хүчингүй болгох асуудлыг Татварын ерөнхий газарт хандаж шийдвэрлүүлэлгүй хувийн компаниар зуучлуулсан нь тус компаниас ихээхэн хэмжээний илүү зардал гарахад хүргэжээ.

Эрдэнэс Тавантолгой компани хувьцаа гаргахтай холбоотой санхүүгийн зөвлөх үйлчилгээ авахаар PWC компанитай 3 удаа нийтдээ 1.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан боловч зөвлөх үйлчилгээний төлбөрийг 1.4 тэрбум төгрөг буюу 200 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Мөн Эрнст энд Янг компанийн санхүүгийн зөвлөхүүдтэй 350.0 мянган фунт стерлингийн гэрээ байгуулахдаа энэхүү дүн нь зөвхөн зөвлөхүүдэд төлөх цэвэр дүн бөгөөд аливаа татварыг ЭТТ компани хариуцна гэж зааснаас шалтгаалан 110.0 сая төгрөгийн татварын өрийг нэмж хүлээн зөвшөөрсөн байна.

Авлага, өр төлбөрийг баталгаажуулах талаар

Эрдэнэт үйлдвэр ХХК 4,673.9 сая төгрөгийн авлага, 150,962.6 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал, 44,830.5 сая төгрөгийн өр төлбөр, Монсам ХХК 336.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Багануур ХК-ийн дотоодын байгууллагаас авах авлагын 36.8 хувь буюу 503.1 сая төгрөгийн авлага нь тайлангийн хугацаанд хөдөлгөөн огт гараагүй бөгөөд төлөгдөх эсэх нь эргэлзээтэй байна.

ААН байгууллагууд Эрдэнэс Тавантолгой ХХК-ийн хувьцааг нэг бүрийг нь 933 төгрөгөөр үнэлэн Үнэт цаасны төлбөр тооцооны төвд худалдан авах хувьцааны төлбөрийг төвлөрүүлсэн байна.

Найм. Тайлант оны аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт:

- Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй гадаад зээлийн ашиглалтыг сайжруулж, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, үр дүнг тооцох;
- Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх зээлийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, цаашид арилжааны банкаар дамжуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Засгийн газар “Сансрын хиймэл дагуулаар телевизийн 10 сувгийн нэвтрүүлэг орон даяар дамжуулах үйлчилгээний төлбөрийн гэрээ”-ний дагуу 10 сувгийн нэрийг тодорхойлж өгөх, гэрээг шинэчилж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Төсвийн эрх захирагчийн эд хөрөнгийн эрхийн талаарх эрх зүйн зохицуулалтыг Төсвийн тухай шинэчилсэн хуультай нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх;
- Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, чиглэлийн яамдад хариуцуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх, хууль зөрчсөн албан тушаалтнуудтай хариуцлага тооцох;
- Хүний хөгжил сангийн алдагдлыг бууруулах, менежментийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх,

- Нийгмийн даатгалын сангийн төрийн санд байршиж буй мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хүү тооцуулах асуудлыг судлан шийдвэрлэх;

Сангийн сайд Ч.Улаанд:

- Улсын өр болон Засгийн газрын мөнгөн хөрөнгө, нөөцийн удирдлагыг зохистой хэрэгжүүлэх;
- Сангийн сайдын 2006 оны 32, 388 дугаар тушаалаар батлагдсан журам, заавруудыг УСНББОУС болон Төсвийн тухай хуульд нийцүүлэн шинэчилж мөрдүүлэх;
- Төв төрийн сангийн гүйлгээг Сангийн сайдын төсвийн багцын тайланд нэгтгэж, хуулийн хугацаанд ҮАГ-т ирүүлж байх, санхүүгийн програм хоорондын уялдааг хангах;
- Хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг барагдуулах талаар зохион байгуулж байгаа ажлыг эрчимжүүлэх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн 2013 онд багтаан цэгцлэх;
- Төсвийн тухай хуулийн 54.2, 8.9.8 дахь заалтуудыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аудит хийгдсэн санхүүгийн тайланг ТЭЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэх талаарх заавар, журмыг баталж, мөрдүүлэх;
- ЗГСНТ болон ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг гаргахад ашиглаж байгаа програм хангамжийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн эх үүсвэртэй байх боломжийг бүрдүүлэх;

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хорооны дарга Д.Цогтбаатар нарт:

- ТӨХ-д бүртгэгдэн тайлагнагдаж буй үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, өмчийн тооллоготой холбоотой судалгааг гаргаж, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу аудит хийгдэхээс өмнө ҮАГ-т ирүүлж байх
- Төрийн өмчийн хороо болон тайланд дурдагдсан зарим ТӨААН-ийн ТУЗ алдаатай шийдвэр, эрх зүйн акт гаргаж байгаад анхаарч, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох
- ТӨААН-үүдийн тайлант оны ажлыг дүгнэхэд аудитаар гарсан зөрчил дутагдлыг харгалзан үзэж арга хэмжээ авч, аудитын зөвлөмжийн биелэлтийн талаархи мэдээллийг ҮАГ-т ирүүлж байх

Арав. Засгийн газрын 2012 оны аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын санхүүгийн байдлын аудит хийгдсэн нэгтгэсэн тайлан

(сая.төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	Мөнгөн хөрөнгө	1,662,317.50	3,574,718.70
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	99,937.00	392,844.20
3	Авлага	2,549,760.80	4,178,819.70
4	Урьдчилгаа	346,528.70	516,310.40
5	Бараа материал	797,668.50	1,140,857.20
6	Нөөц	58,047.50	90,244.90
7	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,514,260.00	9,893,795.10
8	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,481,110.80	1,040,149.40
9	Бусад хөрөнгө	28,000.00	28,000.00
10	Үндсэн хөрөнгө	6,032,543.70	6,767,847.60
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,055,914.50	17,729,792.10
11	Богино хугацаат өр төлбөр	2,994,879.70	4,368,260.20
11.1	Богино хугацаат үнэт цаас	642,967.60	1,449,224.90
11.2	Богино хугацаат зээлийн өглөг	299,820.00	391,560.40
11.3	Өглөг	1,012,869.60	1,324,687.30
11.4	Урьдчилж орсон орлого	1,039,222.50	1,202,787.60
12	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	4,297,498.20	7,496,057.20
12.1	Урт хугацаат үнэт цаас	767,002.10	1,486,760.10
12.2	Урт хугацаат зээл	3,530,496.00	6,009,297.10
13	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,292,377.90	11,864,317.40
14	Засгийн газрын хувь оролцоо	5,763,536.60	5,865,474.70
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,763,536.60	5,865,474.70
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	13,055,914.50	17,729,792.10

Засгийн газрын санхүүгийн үр дүнгийн аудит хийгдсэн нэгтгэсэн тайлан

(сая төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Татварын орлого	3,197,656.70	3,536,292.80
1.1	Орлогын албан татвар	777,888.40	874,878.50
1.2	Өмчийн татвар	17,004.10	22,647.90
1.3	Бараа, үйлчилгээний албан татвар	1,988,588.30	2,172,662.20
1.4	Олон улсын худалдаа, ажил гүйлгээний татвар	337,422.60	327,369.80
1.5	Бусад татвар, төлбөр, хураамж	76,753.40	138,734.30
2	Нийгмийн даатгалын хураамж	548,911.40	782,306.30
3	Тусламж, санхүүжилтийн орлого	360,315.80	2,448,735.80
3.1	Гадаад орнуудаас үзүүлсэн	249,808.80	10,343.00
3.2	Олон улсын байгууллагын тусламж	32,170.90	78,939.50
3.3	Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	78,336.10	2,359,453.30
4	Татварын бус орлого	1,287,436.20	1,812,946.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,394,320.00	8,580,280.90
6	Ажиллагсадын зардал	1,051,801.70	1,533,504.10
6.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	964,390.60	1,406,431.00
6.2	Нийгмийн хамгааллын шимтгэл	87,411.20	127,073.10
7	Урсгал зардал	1,581,936.40	1,803,864.90
7.1	Бараа үйлчилгээний урсгал зардал	1,001,203.20	1,263,871.40
7.2	Хөтөлбөр арга хэмжээний зардал	580,733.20	539,993.50
8	Хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгийн ашиглалт	727,912.70	1,302,382.10
9	Хүүгийн зардал	40,479.90	162,367.70
10	Татаас	178,346.50	221,745.20
11	Тусламж, шилжүүлэг	128,591.60	1,975,525.30
12	Нийгмийн хамгааллын зардал	1,476,385.70	2,133,336.40
13	Бусад зардал	18,023.50	109,375.10
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,203,478.00	9,242,100.80
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	190,842.10	-661,819.90
16	Үйл ажиллагааны бус орлогын дүн	105,436.40	89,623.10
17	Үйл ажиллагааны бус зардлын дүн	417,658.90	70,971.70
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-121,380.40	-643,168.40

Засгийн газрын мөнгөн гүйлгээний аудит хийгдсэн нэгтгэсэн тайлан

(сая төгрөгөөр)

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Татварын орлого	3,195,091.80	3,533,312.50
1.1	Орлогын албан татвар	777,951.50	876,185.50
1.2	Өмчийн татвар	17,004.10	22,784.40
1.3	Бараа, үйлчилгээний албан татвар	1,985,960.20	2,169,538.50
1.4	Олон улсын худалдаа, ажил гүйлгээний татвар	337,422.60	327,369.80
1.5	Бусад татвар, төлбөр, хураамж	76,753.40	137,434.30
2	Нийгмийн даатгалын хураамж	1,012,651.00	775,314.30
3	Тусламж, санхүүжилтийн орлого	350,840.40	2,940,126.30
3.1	Гадаад орнуудаас үзүүлсэн	251,019.60	10,332.90
3.2	Олон улсын байгууллагын тусламж	30,208.20	68,562.90
3.3	Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	69,612.60	2,861,230.50
4	Татварын бус орлого	3,605,622.50	3,993,560.10
4.1	Өмчийн орлого	198,048.50	427,442.20
4.2	Бараа, үйлчилгээний борлуулалт	2,510,910.80	2,858,220.70
4.3	Тусламжаас бусад шилжүүлэг	5,221.90	5,898.30
4.4	Татварын бус бусад орлого	891,441.30	701,998.90
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	8,164,205.70	11,242,313.20
6	Ажиллагсдын зардал	1,195,322.80	1,709,915.40
6.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	1,058,633.20	1,534,207.70
6.2	Нийгмийн хамгааллын шимтгэл	136,689.60	175,707.70
7	Урсгал зардал	3,653,070.60	3,374,830.40
7.1	Бараа үйлчилгээний урсгал зардал	2,877,091.30	2,795,765.00
7.2	Хөтөлбөр арга хэмжээний зардал	775,979.20	579,065.40
8	Хүүгийн зардал	53,182.40	166,637.50
9	Татаас	126,926.70	850,054.70
10	Тусламж, шилжүүлэг	139,740.30	2,372,212.80
10.1	Гадаадын улс орнуудад шилжүүлсэн шилжүүлэг	2,629.80	4,419.80
10.2	Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон шилжүүлэг	137,110.40	2,364,791.60
11	Нийгмийн хамгааллын зардал	1,461,167.50	1,883,047.10
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	6,629,410.20	10,356,697.90
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,534,795.50	885,615.30
14	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	318,703.40	3,403,867.30
15	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,860,004.70	2,570,806.50
16	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,541,301.30	833,060.80
17	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	488,982.20	193,725.10
18	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	482,476.40	1,912,401.20
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,179,841.20	1,662,317.50
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,662,317.50	3,574,718.70

**Засгийн газрын Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн аудит хийгдсэн
нэгтгэсэн тайлан**

(сая төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2011 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	4,098,486.40	1,272,844.60	(800,245.30)	4,571,085.70
1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			319,556.50	319,556.50
2 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,098,486.40	1,272,844.60	(480,688.80)	4,890,642.20
3 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		73,003.30		73,003.30
4 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	918,898.20			918,898.20
5 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			2,373.30	2,373.30
6 Тайлант үеийн үр дүн			(121,380.40)	(121,380.40)
2011 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,017,384.60	1,345,847.90	(599,695.90)	5,763,536.60
2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,017,384.60	1,345,847.90	(599,695.90)	5,763,536.60
7 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(149,430.00)	(149,430.00)
8 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,017,384.60	1,345,847.90	(749,125.90)	5,614,106.60
9 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		13,407.70		13,407.70
10 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	879,569.90			879,569.90
11 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			1,558.90	1,558.90
12 Тайлант үеийн үр дүн	-		(643,168.40)	(643,168.40)
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,896,954.50	1,359,255.60	(1,390,735.40)	5,865,474.70

Арван нэг. Хавсралтууд

Хавсралт А-1

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын мэдээ

/ сая төгрөгөөр/

Д/Д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Санал дүгнэлтийн хэлбэр		Өөрчлөлттэй санал дүгнэлт									Илэрсэн зөрчлийн дүн /сая төг/	Залруулсан дүн	ТЭЗ нар УАГ-т тайлан		
		Зөрчилгүй	Өөрчлөлттэй			Тоо мэдээ зөрүүлэй	Ажил гүйлгээг бүртгэлд дуу тусгасан	Ажил гүйлгээг бүртгэлд тусгаагүй	Ажил гүйлгээг буруу тусгасан	Хамрах хүрээ хязгаарлагдсан	Цаг хугацаа хоцроосноос хамрах хүрээ хязгаарлагдсан	Дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй			Хууль тогтоомж зөрчсөн	Ирүүлсэн огноо	Хугацаа хоцроосон /Ажлын өдрөөр/
			Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах												
А		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
1	Сангийн сайдын төсвийн багц		1						1					9,219.5		ИҮ.15	
2	Гадаад харилцааны сайдын төсвийн багц	1												348.5	2.5	ИҮ.5	
3	Шадар сайдын төсвийн багц	1														ИҮ.5	
4	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багц	1												99,533.4	32,962.4	ИҮ.5	
5	ЦАУЗБУК-ын даргын төсвийн багц	1												516.2		1.25	
6	ЗГХЭГ-ын даргын төсвийн багц	1												2,676.9	2,502.3	ИҮ.5	
7	Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн багц	1												5.0		ИҮ.5	
8	Улсын их хурлын даргын төсвийн багц	1												659.5		ИҮ.10	3
9	Эрүүл мэндийн сайдын төсвийн багц		1					1						971.2	101.2	ИҮ.5	
10	УПЕГазрын даргын төсвийн багц	1												1,442.7	1,399.3	ИҮ.5	
11	Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багц	1												60.3		ИҮ.5	
12	Боловсрол шинжлэх ухааны сайдын төсвийн багц	1												2,518.2		ИҮ.5	
13	Уул уурхайн сайдын төсвийн багц	1												227.5		ИҮ.15	6
14	Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багц	1												278.2	90.5	И.24	
15	Ерөнхийлөгчийн тамгын газрын төсвийн багц	1												146.4	146.4	ИҮ.5	

16	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц	1												859.7	89.2	IY.5	
17	Нийгмийн даатгалын сан	1												1,712.7	352.9	IY.5	
18	Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багц	1												1.5	1.4	IY.5	
19	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багц	1												5.6		IY.5	
20	Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багц	1												12.7		IY.5	
21	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багц		1					1						8,718.0		IY.5	
22	Барилга, хот байгуулалтын сайдын төсвийн багц		1					1						18,745.1		IY.10	3
23	Ерөнхий сайдын төсвийн багц	1												67,436.2	5,074.2	IY.5	
24	Авлигатай тэмцэх газрын төсвийн багц	1												89.5		IY.1	
25	Хууль зүйн сайдын төсвийн багц		1							1				21,373.4	9,752.4	IY.5	
26	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын төсвийн багц	1												28.7		IY.5	
27	Батлан хамгаалахын сайдын төсвийн багц		1								1			8,697.6		IY.5	
28	Хөдөлмөрийн сайдын төсвийн багц	1												5,509.6	444.0	IY.9	2
29	Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багц	1												3.00		IY.5	
30	Зам, тээврийн сайдын төсвийн багц	1												6,973.40	1,053.6	IY.5	
31	Соёл спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багц		1								1			25,000.0		IY.9	2
32	Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багц	1												719.7		IY.10	3
33	Эрчим хүчний сайдын төсвийн багц	1												128,651.2		IY.5	
34	Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн багц	1														IY.5	
35	Хүний хөгжлийн сан	1												67,951.3	63,451.3	IY.15	
ДҮН		28	7	-	-	-	-	3	-	-	1	-	3	481,092.4	117,423.6		

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмж

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт /2011 он/				Аудитын мөрөөр өгсөн зөвлөмж /2012 он/											
		Нийт зөвлөмжийн тоо	Үүнээс			Нийт өгсөн зөвлөмж	Ач холбогдлоор			Үүнээс							
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатандаа	Хэрэгжээгүй		№1	№2	№3	Арвалан хэмэлтийг сайжруулах	Үр ашгийг дээшлүүлэх	Үр нөлөөг сайжруулах	Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулах	Хариуцлагыг сайжруулах	Бусад	
1	Сангийн сайдын төсвийн багц	3	2	1		2	1	1							1	1	
2	Гадаад харилцааны сайдын төсвийн багц	1	1			5	5			1	1	2			1		
3	Шадар сайдын төсвийн багц	4	4			3	3									2	1
4	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багц	2	2			5	1	4				1	1	1	1	2	
5	ЦАУЗБУК-ын даргын төсвийн багц	1	1			1		1								1	
6	ЗГХЭГ-ын даргын төсвийн багц	2	2			3		3			1		1	1			
7	Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн багц	2	2			1		1				1					
8	Улсын их хурлын даргын төсвийн багц	2	1		1	2		2		1	1						
9	Эрүүл мэндийн сайдын төсвийн багц	4	3	1		6	2	4				2	1	1	2		
10	УПЕГазрын даргын төсвийн багц	2	1		1	3		3							2	1	
11	Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн багц	1	1			2		2					1	1			
12	Боловсрол шинжлэх ухааны сайдын төсвийн багц	3	2		1	5		5			1	1			1	1	1
13	Уул уурхайн сайдын төсвийн багц					7	2	5		1		2	1	1	2		
14	Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн багц	2	2			4		4				1	1		1	1	

15	Ерөнхийлөгчийн тамгын газрын төсвийн багц					5	5			1	1	1	1	1
16	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц	1	1			2	2				1		1	
17	Нийгмийн даатгалын сан	3	3			3	3					1	1	1
18	Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багц	4	4			2	2						1	1
19	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багц	1	1			1	1							1
20	Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн багц	1		1		2	1	1			1			1
21	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын төсвийн багц	4	4			4	4			2	1			1
22	Барилга, хот байгуулалтын сайдын төсвийн багц					1	1							1
23	Ерөнхий сайдын төсвийн багц	3	3			2	2					1	1	
24	Авлигатай тэмцэх газрын төсвийн багц	3	3			1	1							1
25	Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багц	4	1	3		6	6							2 3 1
26	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын төсвийн багц	3	2	1		2	2			1		1		
27	Батлан хамгаалахын сайдын төсвийн багц	4	1	2	1	3	1	1	1		1			1 1
28	Хөдөлмөрийн сайдын төсвийн багц					4	4					1		1 2
29	Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багц	1	1			2	2					1		1
30	Зам, тээврийн сайдын төсвийн багц	4	3		1	3	3							1 1 1
31	Соёл спорт, аялал жуулчлалын сайдын төсвийн багц					4	1	1	2		1	1	1	1

32	Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багц					5	2	1	2					1	3	1
33	Эрчим хүчний сайдын төсвийн багц	5	5			3	2	1			1	1	1			
34	Хүний эрхийн үндэсний комиссын даргын төсвийн багц															
35	Хүний хөгжлийн сан	5	4	1		2	1	1			1				1	
Дүн		75	60	10	5	106	26	75	5	4	12	16	13	25	30	6

Хавсралт Б-1

Орон нутгийн ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын мэдээ

(сая төгрөгөөр)

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Дүгнэлтийн хэлбэр				Илрүүлэлт									
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан	Төлбөрийн акт		Албан шаардлага		Сахилгын шийтгэл хүлээл-гэхээр шилжүүлсэн асуудал		Залруулсан алдаа		Өгсөн зөвлөмж	
						тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн		тоо
1	Архангай	1				3	72.2								1
2	Баян-Өлгий		1												3
3	Баянхонгор	1				6	4.0					1	27.9		7
4	Булган	1				1	10.0	7	35.7			2	15.1		4
5	Говь-Алтай	1													2
6	Говьсүмбэр		1			4	18.9					2	1,513.1		4
7	Дархан-уул	1													5
8	Дорноговь	1										2	3,565.7		2
9	Дорнод	1				31	17.3	2	6.1	3			777.9		10
10	Дундговь		1			1	9.6	1	62.3	6			1,147.0		5
11	Завхан	1											43.1		2
12	Өвөрхангай	1													8
13	Өмнөговь	1													3
14	Орхон	1				5	32.3	1	87.4	4					3
15	Сүхбаатар	1				3	2.4								4
16	Сэлэнгэ		1				10.2		10,025.1				1,750.3		9
17	Төв	1					53.4		535.6				1,538.7		3
18	Увс		1			1	13.1						239.3		6
19	Ховд	1													5
20	Хөвсгөл	1											839.4		9
21	Хэнтий	1				6	37.2	9	30.5				411.2		8
22	Нийслэл		1				920.2		2477.6				10,246.6		4
Дүн		16	6			61	1,200.8	20	13,260.3	13		7	22,115.3		107

Хавсралт Б-2

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмж

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Өгсөн зөвлөмжийн тоо	Үүнээс		
			Хэрэгжсэн	Хэрэгжих шатандаа	Хэрэгжээгүй
1	Архангай	3		2	1
2	Баянөлгий	3	2	1	
3	Баянхонгор	10	8	2	
4	Булган	8	6	1	1
5	Говьалтай	5	4		1
6	Говьсүмбэр	7	7		
7	Дархан-Уул	5	4		1
8	Дорноговь	11	3		8
9	Дундговь	5	4		1
10	Дорнод	21	13	6	2
11	Завхан	5	4	1	
12	Өвөрхангай	10	10		
13	Өмнөговь	2	2		
14	Орхон	6	4		2
15	Сүхбаатар	5	4		1
16	Сэлэнгэ	5			5
17	Төв	5	4		1
18	Увс	14	11		3
19	Ховд	5	4		1
20	Хөвсгөл	4		2	2
21	Хэнтий	7	5		2
22	Улаанбаатар	25	20	5	
Дүн		171	119	20	32

Аудитын дүнгийн нэгдсэн судалгаа

(сүүлийн 3 жилээр)

/тэрбум төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	Тайлбар (3/2)
	А	1	2	3	4
1	Аудитаар илрүүлсэн алдаа зөрчил	4,060.7	4,311.0	4733.0	Өмнөх оноос 422.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.
2	Аудитаар тогтоосон төлбөрийн акт	11.9	48.7	1.5	Өмнөх оноос 47.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.
3	Аудитаар өгөгдсөн албан шаардлага	473.9	89.0	549.5	Өмнөх оноос 460.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.
4	Тендерээр шалгарсан хувийн хэвшлийн аудитын компаниудын илрүүлсэн алдаа зөрчил	85.8	149.6	777.0	Өмнөх оноос 627.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2013 оны 6 сарын 4 өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Төрийн өмчийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга нарт, аудитаар тогтоосон акт, албан шаардлагын биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд хариу ирүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд тус тус зөвлөсүгэй.

Тав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын газрын захирал С.Энхзаяад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070404

